



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 6/65

Дуурсах

Ц.Доржхандыг ажилд томилж,
цагдаагийн цол нөхөн олгох тухай

Үндэсний архивын газрын 2003 оны “Төрийн архивын ажлын үндсэн заавар”-ын 7.8.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Цэрэн овогтой Доржхандаас гаргасан хүсэлтийн дагуу Баянхонгор аймгийн засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн даргын 1995 оны 04 дүгээр сарын 19-ний 50 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 1998 оны 178 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 2307/11 дугаартай лавлагаа, цалингийн баримт зэргийг баримтлан Цэрэнгийн Доржхандыг Эрүүлжүүлэх, баривчлах байрны хүлээн авах бага эмчээр томилж, ахлагч цолыг 1995 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн нөхөн олгосугай.
2. Хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хөдөлгөөн хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190215



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 06 өдөр

дугаар 6/66

Дуурсах


Шагнах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнал, урамшил олгох” /код 925/-ын 925.3.1, “Байгууллагын даргын тушаал гаргах” /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар хэсгийн 8.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2019 оны “Буудлага”-ын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байранд шалгарсан хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Төмөрсүх, эрүүлжүүлэх, saatuuлах байрны эмч, цагдаагийн ахлах дэслэгч Ю.Мөнхжин, Дотоод хэргийн их сургуулиас зохион байгуулсан “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ахлагч бүрэлдэхүүний үүрэг оролцоо, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд тэргүүн байр эзэлсэн зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн дэд ахлагч Б.Цээпилмаа, Аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлеттикийн тэмцээний 5000, 3000 км гүйлтийн хошой аварга болсон харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Дансүрэн нарын албан тушаалын сарын үндсэн цалинг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь, Аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлеттикийн тэмцээний 1500 км зайд бичиг хэргийн эрхлэгч, бичээч, архивч, цагдаагийн ахлагч Э.Мөнхгэрэл, үндэсний сурын харвааны тэмцээнд багийн цагдаа, цагдаагийн ахлагч Л.Мөнхзаяа нар нь гутгаар байранд тус тус орсон тул албан тушаалын сарын үндсэн цалинг 1 /нэг/ сар 10 /арван/ хувиар нэмж шагнасугай.

2. Шагнагдсан алба хаагчдын цалинг заасан хувь, хэмжээгээр тооцон цалингийн сандаа багтаан нэмж олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 6/67

Дуурсах

Э.Баасансүрэнд сахилгын
шийтгэл оногдуулах тухай

Монгол Улсын төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” /код 136-/ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, “Сахилгын шийтгэл ногдуулах” /код 914-/ын 914.3.3, 914.3.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2019 оны 06 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр аймгийн прокурорын газраас ирүүлсэн 14/04 дугаартай прокурорын шаардлагад заагдсан зөрчлийн дагуу албаны шалгалт явуулахад Монгол улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан “Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөр шийдвэрлэж, гаргасан шийдвэрээ даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дугаартай тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн 12 дугаар зүйлийн 12.12 дахь хэсэгт заасан “Хуулиар харьяалуулсан хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн бол сануулах” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Эрхийг Баасансүрэнд Цагдаагийн албаны тухай хуулийн 81.4 дүгээр зүйлийн 81.4.1 дэх хэсэгт заасныг баримтлан Сануулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн дэслэгч Э.Баасансүрэнд дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг, хариуцсан алба хаагчтайгаа ажиллаж өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, алба хаагчдынхаа сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зааварчилгаа өгч, хуульч шуурхай ажиллагааг хэвшүүлэн ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-д үүрэг болгосугай.

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190227

3. Цагдаагийн дэслэгч Э.Баасансүрэнгийн хувийн хэрэг болон хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.АНХБАЯР





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 6/68

Дуурсах


Г.Цогтсайханд чөлөө олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136-/ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Алба хаагчид чөлөө олгох” /код 934/-ын 934.2.3 /б/-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ар гэрийн гачигдлын улмаас чөлөө хүссэн харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Гарамын Цогтсайханд 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл ажлын 6 хоногийн цалинтай чөлөө олгосугай.
2. Цалинтай чөлөө олгосон цагдаагийн ахлах ахлагч Г.Цогтсайханы цалинг зохих журмын дагуу бодож, олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ЦАНХБАЯР





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 6/69

Дуурсах

Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн зургаадугаар бүлгийн 6.5 дахь хэсэг, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код-136/ 136.5.2-ийн “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2019 оны 07 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Байгууллагын дотоод журам”-аар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ амжилттай биелүүлж, хамт олноо манлайлан ажиллаж байгаа болон гаргасан зөрчлийн шинж, чанарыг нь харгалзан Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Бадраагийн Мөнгөнтулга, хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Мөнхөөгийн Бямбадорж нарыг 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн сахилгын шийтгэлгүйд тооцсугай.

2. Хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцсон алба хаагч нарт дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг үүрэг болгосугай.


3. Хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019



20190245



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 6/70

Дуурсах

Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн зургаадугаар бүлгийн 6.5 дахь хэсэг, мөн даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код-136/ 136.5.2-ийн “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2019 оны 07 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Байгууллагын дотоод журам”-аар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ амжилттай биелүүлж, хамт олноо манлайлан ажиллаж байгаа болон гаргасан зөрчлийн шинж, чанарыг нь харгалзан Мөрдөгч, цагдаагийн ахмад Наранцэцэгийн Түмэннасанд 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн сахилгын шийтгэлгүйд тооцугай.

2. Хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцсон цагдаагийн ахмад Н.Түмэннасанд дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг үүрэг болгосугай.


3. Хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/ -д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019



20190247



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 6/71

Дуурсах

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэн,
ажил хариуцуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3, мөн журмын 5 дугаар зүйлийн 5.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136-/ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвшөөрлийн дагуу Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ц.Анхбаяр нь ээлжийн амралт авах болсонтой холбогдуулан 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс энэ оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-өөр даргын зарим чиг үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.


2. Цагдаагийн газрын даргын өгсөн үүрэг, ажлын чиглэл болон ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан зарим зорилтын хүрээнд хийгдэх ажлуудыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-д хариуцуулсугай.

3.Дээрх зарим чиг үүргүүдийг хэрэгжүүлэн биелэлтийг заасан хугацаанд гаргаж танилцуулан ажиллахыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /Цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.АНХБАЯР





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 5/72

Дуурсах

Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.9 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны A/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн зургаадугаар бүлгийн 6.5 дахь хэсэг, мөн даргын 2017 оны A/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код-136/ 136.5.2-ийн “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын даргын 2019 оны 07 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Байгууллагын дотоод журам”-аар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ амжилттай биелүүлж, хамт олноо манлайлан ажиллаж байгаа болон гаргасан зөрчилдөө дүгнэлт хийж байгаа зэрэг шинж, чанарыг нь харгалзан Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Найманжингийн Өнөмөнхийг 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн сахилгын шийтгэлгүйд тооцсугай.

2. Хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцсон цагдаагийн хошууч Н.Өнөмөнхөд дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг үүрэг болгосугай.


3. Хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/ -д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019



20190251